

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Цоожэд” өрхийн эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/003/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Булган аймаг дахь Төрийн аудитын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол Утас: 70342580 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу,



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.08.13 № 333

танай _____ ны № _____ т

ЦООЖИД ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
ӨСӨХБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Цоожид" ӨЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд албан хаагч нарт анхан шатны баримтгүй нийт 497.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, нийт 1,353.4 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин нийт 990.0 мянган төгрөгийг зарцуулсан, нийт 32,350.3 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулж баримтжуулаагүй, тооцоо нийлсэн акт байхгүй, Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлсэн нийт 373.7 мянган төгрөгийн эм, эмнэлэгийн хэрэгсэлийг орлогод аваагүй, вакцины тайлангийн үлдэгдэл тооллогын дүнгээс 221.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, Яаралтай эмчилгээний эм, эмнэлэгийн хэрэгслийн 508.6 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 25.10, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2, 72.1, 72.4.1, 72.4.4, 72.5.1, 73.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 14.4.5, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд

зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон материаллаг

632502733

байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй. Эрүүлмэндийн Сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/212 дугаар тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг баримтлан ажилладаг.

Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна гэж тус үлгэрчилсэн дүрэмд заасан байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна гэж заасан ба төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.

Аудитын гол асуудал

Өрхийн эрүүл мэндийн төв нь сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрхийн эрүүл төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг.

Тайлант онд 544,612.1 мянган төгрөгийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас 460,421.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 40,790.3 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээ байгуулж 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлээгүй ч гурвалсан гэрээг 82.0 хувьтай дүгнүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд

дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	60,992.7	77,053.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	247,071.9	251,600.7
Нийт хөрөнгийн дүн	308,064.6	328,654.5
Нийт өр төлбөрийн дүн	114.4	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	307,950.2	328,654.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	308,064.6	328,654.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	430,256.0	544,612.2
Үйл ажиллагааны зардлын дүн	437,479.8	520,073.9
Үйл ажиллагааны үр дүн	(7,223.8)	24,538.3
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(3,834.0)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(7,223.8)	20,704.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	315,174.1	307,950.2
Тайлант оны үр дүн	(7,223.8)	20,704.3
Эцсийн үлдэгдэл	307,950.2	328,654.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	387,142.7	460,421.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	364,223.3	458,718.2
Үйл ажиллагааны ЦМГ	22,919.4	1,703.7
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(11,370.0)	(10,690.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	11,549.4	(8,986.3)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,350.2	12,899.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,899.6	3,913.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	469,408.2
Урсгал зардал	-	458,718.2
Хөрөнгийн зардал	-	10,690.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	460,421.8
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	140.0

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Цоожэд” БГБХ нөхөрлөл гэсэн статустай байна. Өмчийг бүрэн бус нөхөрлөлийн гишүүд эзэмшиж байна.

“Цоожэд” өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй, чанартай, хүртээмжтэй үзүүлнэ
- Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, шаардлагатай лавлагаа, тусламжийг цаг алдалгүй зохион байгуулан тусламж үйлчилгээг тасралтгүй иргэдэд тусламж үйлчилгээг мөн адил тэгш хүртээмжтэй үзүүлнэ.
- Гамшиг осол, нийтийг хамарсан халдварт өвчний үед аймгийн онцгой байдлын комисс, эрүүл мэндийн газрын шийдвэрийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулан, үр дүнг тооцож ажиллана.
- Эрүүл мэндийг дэмжигч иргэн, өрх, байр, гудамж байгууллага боох хөдөлгөөнийг өрнүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус өрхийн эмнэлэг нь улсын бүртгэлд ББН буюу бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, байгууллагын төрөл ашгийн төлөө гэсэн бүртгэлтэй байгаа учир санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгээгүй харин Сангийн сайдын 2023 оны 299 дугаар тушаалын дагуу бэлтгэх шаардлагатай байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д, санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, батлуулж, биелэлтийг гаргаж ажиллах шаардлагатай байна.

Тав. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайланг программаар бүрэн гаргаагүй алдааг аудитын явцад гаргуулсан.

Аудитаар нийт 36,294.7 төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,944.2 мянган төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 32,350.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 36,294.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 31,373.1 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Нэгдүгээр сард албан хаагч нарт анхан шатны баримтгүй нийт 479.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4, 20.2.5, 20.2.13 -д заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоолоо.

2. Тайлант онд нийт 1,353.4 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4, 20.2.5-д заасан заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоосон.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин албан хаагчдад гадуур өмсөх жигдэрсэн куртик авахад нийт 900.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.14, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоосон.

4. Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлсэн 373.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод аваагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.1, 72.4.1, 72.4.4, 72.5.1, 73.1.4, 73.2, НББ-ийн тухай хуулийн 14.4.5-д заасан заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоосон.

5. Вакцины тайлангийн үлдэгдэл тооллогын дүнгээс 221.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.1, 72.4.1, 72.4.4, 72.5.1, 73.1.4, 73.2, НББ-ийн тухай хуулийн 14.4.5-д заасан заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоосон.

6. Яаралтай эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгслийн 508.6 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.1, 72.4.1, 72.4.4, 72.5.1, 73.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.1, 20.1.4, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байгаад төлбөрийн акт тогтоосон.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулж баримтжуулаагүй, тооцоо нийлсэн акт байхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д заасан заалттай бүрэн нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэх ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг программаар бүрэн гаргаагүй	1						1					
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэгдүгээр сард албан хаагч нарт анхан шатны баримтгүй нийт 479.2 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон	1	479.20	1	479.2								
Тайлант онд нийт 1,353.4 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан	1	1,353.40	1	1353.4								

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй шилжүүлсэн 373.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод аваагүй	1	373.70	1	373.70								
Вакцины тайлангийн үлдэгдэл тооллогын дүнгээс 221.2 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	221.20	1	221.2								
Яаралтай эмчилгээний эм, эмнэлгийн хэрэгслийн 508.6 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримт байхгүй	1	508.60	1	508.60								
Бараа материалын тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулж баримтжуулаагүй, тооцоо нийлсэн акт байхгүй	1	32,350.30					1	32,350.30				
Дүн	6	35,286.40	5	2,936.10	0.0	-	1	32,350.30	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0.0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин албан хаагчдад гадуур өмсөх жигдэрсэн куртик авахад нийт 900.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	900.00	1	900.00	0	-		
Дүн	1	900.0	1	900.0	-	-	-	-
Нийт дүн	1	900.00	1	900.0	-	-	0	0